



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 4/МЗ

Зуунмод

Тооллогын комисс байгуулах
тухай

Монгол Улсын "Статистикийн тухай", "Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай" хуулийн дагуу хүн ам, орон сууцны ээлжит тооллогыг 10 жил тутам, завсрын тооллогыг 5 жил тутам явуулах ёстой бөгөөд 2015 онд энэхүү ээлжит завсрын тооллогыг зохион байгуулах хуулийн хугацаа тохиож байгаа тул түүний бэлтгэл ажлыг эхлүүлэх ажлын хүрээнд сумдын тооллогын комиссыг байгуулан үүрэгжүүлэх зорилгоор Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6, 29 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Хүн ам орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогыг зохион байгуулж явуулах сумын тооллогын комиссыг байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Сумын тооллогын комиссын дарга нарт дараахь арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосугай. Үүнд:

-Завсрын тооллогын асуудлаар аймгийн тооллогын комиссоос өгсөн удирдамж, чиглэлийн дагуу тооллогын ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах

-Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд орон сууц, хашаа, гудамж, талбайн нэр, хаягийг цэгцлэх, баг, хорооны хилийн цэсийг тогтоох ажлыг зохион байгуулах

-Иргэний бүртгэлийг бүрэн хөтлөх, иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах,

-Хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэлтийн явцад хяналт тавих, сайжруулах ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг хангах, мэдээлэх, мэдээллийн сангийн бүрдэлийг бүрэн дуусгах

-Нутаг дэвсгэртээ байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй иргэн, орон гэргүй хүн, албан бусаар ашигт малтмал олборлогчид болон тухайн нэгжид оршин суух бүртгэлгүй иргэдийн бүртгэлийг цэгцлэх

-Хүн ам, орон сууцны завсрын тооллого болон хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлын зорилго, ач холбогдол, үүнд иргэдийн оролцуулах үүргийн талаар ухуулан сурталчлах ажлыг зохион байгуулах

01 0460

-Багт хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжуулалт хариуцсан гэрээт ажилтан авч ажиллуулах

-Хууль тогтоомжинд заасан бусад үүрэг

3. Хүн ам, орон сууцны 2015 оны завсрын тооллогыг Үндэсний статистикийн хорооноос өгсөн мэргэжил, арга зүйгээр хангаж, ажлын явц байдалд хяналт тавьж ажиллахыг Аймгийн тооллогын комиссын орлогч дарга, Статистикийн хэлтсийн дарга /Ж.Отгончулуун/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАЯРБАТ

Аймгийн Засаг даргын 2015 оны
04 дүгээр сарын 26 -ны өдрийн
117 дугаар захирамжийн хавсралт

КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Тооллогын комиссын дарга:

-Засаг дарга

Тооллогын комиссын орлогч дарга:

-Санхүүгийн албаны дарга

Гишүүд:

- Тамгын газрын дарга
- ИТХ-ын нарийн бичгийн дарга
- Байгаль орчны асуудал
хариуцсан мэргэжилтэн
- Хууль эрх зүйн ажилтан
- Нийгмийн бодлогын асуудал
хариуцсан мэргэжилтэн
- Газрын даамал
- Эрүүл мэндийн төвийн дарга
- Сургуулийн захирал
- Цагдаагийн хэсгийн төлөөлөгч
- Улсын бүртгэгч
- Татварын улсын байцаагч
- Нийгмийн даатгалын байцаагч
- Нийгмийн халамжийн ажилтан
- Багийн засаг дарга нар
- Төрийн сангийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: